

**АМЬТНЫ СЭДЭВТ СҮГ ЗУРЛАГЫГ ТАЙЛБАРЛАХ
ЗАРИМ АСУУДАЛД**

Ч.Болдбаатар¹

Саяхан болтол чулуун зэвсгийн үеийн дурсгалыг баруун Европ, Пиреней, Альпийн нуруунаас цааших чуулбарт тулгуурлан тайлбарлаж байлаа. Гэтэл өмнөд Уралын Каповын агуйгаас 1959 онд, А.В.Рюмины олсон зургийг (долоон арслан заан, хамар дээрээ эвэртэй хоёр хирс, зэрлэг адууны зосоор өнгөлсөн сүгийг) өнө эртний урлагийн дурсгал хэмээн үзсэнээс хойш Ази дахины сүг зурлагын голомтыг судлах ажил эрчимжиж, хүй нэгдлийн овог аймгийн ахуй хийгээд оюунлиг соёлын бүхий л хүрээг судлахад чиглэж, нэлээд олон чуулбарыг бүртгэн авч заримыг нь нийтлэх боллоо. Үүнээс үүдээд хадны зургийн он цагийг тогтоох (тус нутагт оршиж байсан түүхэн хөгжлийн аль үед холбогдох), галбиршлын хэв маяг, утгыг тайлах нь арга зүйн хувьд боловсорч байгаа боловч эртний хүмүүсийн тэрлэсэн занга тэмдэгтэд ончилох дохионы далд учир холбогдол, тухайлсан эхийн дүрслэл загварчлалыг нарийвчлан судлах нь чухал шаардагдсаар байна. Тиймээс бид, эрт баларын сүг зурлагыг түүхэн туршлагын хэмжээнд бус ойлгохуйн элемент болох талаас нь авч үзэхийг зорьж буй.

Хүмүүс биологийн талаар хамтарсан бүлэг болж нэгдсэнээс хүйн байгуулал эхтэй ч тэр нь оршин байгаа овгийн бүтцийн зохист байдал, тогтворт харилцаа, тохирсон хориг сэлтийг мөрдөх хийгээд тухайн үйл амьдралыг түүхэн зайлшгүй эргэлтэд оруулах боломж руу чиглүүлж шаарддаг. Уг шаардлагад юуны өмнө хүний хүсэл, эсвэл айж болгоомжлох хүчин зүйлийн тал ч нөлөөлдөг. Анхнаасаа хүний хүсэл эрхэм зүйлийн угтлаар биш харин айдас аюул, зовлонд хүргэж болохуйц байдлыг мэдрэхтэй холбогддог билээ.

Иймд орчин цагийн нийгэм-түүхийн онолын судалгаанд хүний амьд явах утга учрыг илрүүлэх асуудлыг хөндөн тавьдаг. Тэгэхдээ судлагдахуунаа жирийн амьдралаас биш хүний дотоод ертөнцөд дагалдаж орших үндэс язгуураас эрэлхийлэхийг зааглаж тайлбарлах боллоо. Нэг хэсэг судлаачид ухамсаргүйн бүтэц, түүний түлхэцийг психоанализтай холбон, тэндээс тэмдэгших нийтлэг гарвалыг хайж байхад, нөгөө хэсэг нь хүй нэгдэл, овгийн байгууллын хүмүүс эдүгээтэй адил логик дүрмээр сэтгэдэг авч сэтгэлгээнд мэдрэмж гол үүрэгтэйг тогтоосон бол зарим нь түүхийн өмнөх үеийн сүг зурлагын маягийг шинжиж “шидчилэх”, “логикчлох” хоёр загвартай байсан гэх санааг дэвшүүлжээ.

Үүний чацуу К.Юнг хүнд “хамтын ухамсаргүй” үйлдэл байнга дагалддаг нь тохиолдлын шинжтэй бус хүний төрөлх зөн совин, зовнин мэдрэх чадварыг илтгэдэг

¹ Доктор, дэд профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

гэж үзсэн. Түүний хөндсөн ухамсар үгүй түлхэцийн тухай зарчим бол хүн гэх амьтан байгалийн элдэв юм үзэгдлээс өөрийн зөнгөөр хамгаалагдахыг дураар сонгодоггүй, харин тийм сэрэл анхнаасаа өгөгдсөн гэх үндэслэлд суурилдаг. Ингэж ойлговол, сүг тэрлэх үйл тахилга ч ялгаагүй овог аймгийн хувь заяаг “сүүдэр” (амь зурлага) ивээдэг учраас ууж, идэх болоод байгалийн хар хүчнээс өөрсдийгөө зайлуулах физиологи-биологийн төвшинд хэрэглэгддэг байх нь. Сүг зурлагын дохио занга ихэнхдээ хүйсийн зөн совинг хөгжөөж, үгүй бол овгийн байгууллын хувь заяаг ер бус чадлаар эрхшээдэг нь ч үүний улбаа байж мэднэ.

К.Юнг төдийгүй өрнөдийн хадны зургийг ухамсаргүйн үүдлээр шинжсэн судлаачид, тухайлбал А.Леруа-Гуран сүгийн бүдүүвчийн утгад анхлан “болзолт” шинж тусгагддаггүйг нягтлаад дүрст чуулбар урт удаан хувьслын явцад бүрэлджээ гэсэн нь бидний судалгаанд онол арга зүйн удирдамж болж байна. Нөгөөтэй, Э.Пьетт, А.Брейлийн тайлсан primitive даллагад хэрчлээс тавих үйл зонхилж байснаа, олзоо (ав хомроого) домнож гороолон тиглэх хэрэглээ рүү шилжсэн гэснийг бас бодолцмоор зүйл. Ямартаа ч, хүний “өөрийгөө хамгаалах” гэсэн зуршил далд ухамсарт бүрэлдэхдээ заавал туршлагатай (зүүд, айдас...) нэгдэж ухамсарт үйлдэл болдог тул сүгийн зурлагыг галбиршлынх нь хувьд “I art parietal” эсвэл “I art mobiler” гэж зааглан ангилах болсон билээ. Ингэж зурлагыг галбиршлаар ангилсан нь зөвхөн морфологи судалгаанд төдийгүй дохио тэмдгийг тайлах асуудлыг хөндөхөд тустай. Эндээс сүгийн галбиршилд агуулагдах нэгэн утгат (моноэлементлиг), элдэв утгат (полиэлементлиг) зурлагын тухай яриа үүсэх нь дамжиггүй.

Хүй нэгдлийн цаг үеийн үлдэц монгол нутгаас олддог сүг сэлтэд дээрх утга галбиршдаг ч яг адилаар зүйлчлэх аргагүй хоёр зүйл бий. Нэгд нь, зурлагад гол төлөв хээлийг (умайг) эх галбиршил болгодог шиг үүтгэгч эхийн буумлыг амьтны төрхтэй (зооморф) гороолсноос анхдагч утгыг шилжвэрээс ялгахад бэрхтэй байгаа явдал. Хоёрт нь, хээл хээг тодотгосон толбо тэмдэг, ээлтэй бууцаа сахихч хэвтүүлээ домнодог цээр хориг (занга) бараг мартагдаж орхигдсонд оршино. Умай, мод мэт ац тавилын зурлага эх зурлагаа гэсэн нь хүйсийн мэдрэмж (зөн совин) яваандаа эрхлэх ахуйтай сүлэлдэж хувилснаас шалтгаалсан, үгүй бол зурлагаар зан үйлээ тайх шаардлагаас түрдсэн байж болох. Тэгээд ч эртний хүмүүсийн билгийн зөн хүслийн дотор зайлшгүй занга дүгэлддэгийг Э.Тайлор, К.Леви-Стросс, Л.Леви-Брюль, З.Фройд нэг бус удаа судалгаандаа хөндсөн нь сонирхолтой асуудал. Хадны зурлага болхи тойм мэт харагдавч зурлага дохионы угшил нь галбир бүтээврийн ерөнхий бүдүүвчийг зөн увидаас талаас нь тэрлэдэгтэй шууд хамааралтай юм.

Иймээс, сүгийн галбиршлыг утгачлан тайлбарлахын тулд анхаарвал зохих зүйл нэлээдгүй байна. Хамгийн гол нь хүй нэгдлийн нийгмийн “синкретик” төсөөлөл, түүнийг илэрхийлэхэд хэрэглэдэг “бибинар” тэмдэглэгээ чухал. Гэхдээ зурлага тэрлэх үйлийг дом шившлэг дангаар гүйцэтгэдэггүй бөгөөд гагцхүү гадаад ертөнцийн нөлөөнөөс цэвэр транс-экстаз ахуйд шилжих үйл явц зайлшгүй холбоотой болно. Үүний эрхээр баларлиг цагт хүн айдсаа дарах, түүнийг аргадах болсноор далд хүч чадалтай зүйлийг энгийн зүйлээс ялгах болж иржээ. Нэг ёсондоо зурлага сүг бол өгөө авсаа хоёрын тохироо учраас “амьдчилж” ёсчлох нь “ид” хөгжөөж буй хэрэг болой. Үүнийг тайлбал, яаж аргадсанаас бүх зүйл шалтгаалдаг буюу амьтны биеийг гороолж татсанаар сүг амилдаг хэмээн төсөөлдөг болж таарч байна.

Энэ талаас нь “Монгол” хэмээх нэрийн дор түүвэрлэгдсэн эртний сүгийн баялаг сан хөмрөгийг түүхч археологчид, бусад улсын эрдэмтэн судлаач нар багагүй шинжин

тогтоожээ. Эшилбэл, Уралын хавийн хадны зурлагад дүрсийн гороо хүрээг ихэвчлэн "цэглэж" гаргасан байхад тус нутгаас олддог хадны чуулбарт галбирыг голцуу ховил татаж түүнийгээ "зосоор" өнгөлж домносон нь бий. Эдгээрээс эртний хүмүүс юуг эрхэмлэж, юугаар шидэлж, яаж ёсочлож байсныг ажиглаж болно. Ялангуяа гороо тиг татаж шидлэхдээ явдлаар нь домнох биш, зөвхөн гэтлэгэх үйлээ тасалж дохио болгодог заншил түгээмэл байжээ. А.П.Окладников "Центрально-азиатский очаг первобытного искусства" хэмээх бүтээлдээ "хадны сүг зургийн дурсгалаар нэн баялаг дэлхийн цөөхөн орны нэг нь Төв Ази дахь Монгол улс мөн" хэмээсэн нь үүнээс улбаатай биз.

Аливаа дом бүхий зурлагад буй "аморф" үүдэл өөрөө бусдад хамаарч, бусад нэг бүр нь үлдсэн бусдыг орлодог ("pars pro toto") зарчимтай байдаг ч ялгаагүй монгол дахь уугуул зурлагын өвд агуулагдаж таарна. Тэрхүү зарчмыг тэрлэсэн дурсгалын нэг нь Ховд аймгийн Манхан сумын нутагт буй Хойт Цэнхэрийн агуйн чуулбар юм. Нутгийн нүүдэлч малчид магадгүй олон зуун жилийн өмнөөс мэдэж байсан эдгээр сүг эртний хүмүүсийн бүтээл мөн болох нь шинжлэх ухааны үүднээс нотлон тогтоогдох хүртлээ урт удаан хугацаа өнгөрүүлжээ. Хойт Цэнхэрийн агуйн зургийг анх 1952 онд түүхийн үүднээс тодорхойлон мэдээлж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж ирсэн хүн бол газар зүйч эрдэмтэн О.Намнандорж байлаа. Гэвч тэрээр уг дурсгалын бүтээгдсэн он цагийг 3-4 мянган жилийн өмнөх үетэй холбогдуулан үзсэн нь хараахан ташаа болжээ. О.Намнандорж эл зурлагыг хуулбарлан аваад Ховд аймгийн орон нутгийг судлах музейд тавьсныг Чехословак улсын Дорно дахины судлаач Павел Поуха хуулан авч шинжилж үзээд хүй нэгдлийн үеийн хүний гараар бүтээгдсэн байх гэдэг таамаглал дэвшүүлжээ.

Харин 1966 онд А.П.Окладниковын удирдсан Зөвлөлт-Монголын эрдэм шинжилгээний анги тус агуйн зургийг шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судалсан байна. Хойт Цэнхэрийн агуйн чуулбарын тухай А.П.Окладников бичихдээ "1966 оны зун цаг, Азийн төвд Монгол Алтайн Хойт Цэнхэрийн агуйн хананд үхэр, ямаа болон тэмээн хяруултай маш төстэй шувуу, заан шиг соёотой амьтдын өнгөтэй дүрс зураг олдлоо. Донж төрх, арга барилаараа эдгээр зураг баруун зүгийн ориньяк урлагийг юуны өмнө санагдуулав" гэжээ. Энэ нь тус бэлчээрт идээшигч эртний хүмүүс Европ, Африкийн эртний хүмүүсийн адил сэтгэн бодож, аж амьдралын байдал, шидчилэх аргаа сийлэн урлаж, илэрхийлэн мөнхжүүлснийг батлан харуулах баримт билээ. Саяхан болтол хад чулууны хамгийн эртний дурсгалыг Сибирь-Скитийн үеийнхтэй төстэй хадны сүг зураг, эртний Түрэгийн үеийн дурсгал гэж хоёрхон хэсэгт хуваан үзэж байлаа. Гэтэл одоо "чулуун зургийн" музей болсон хойт Цэнхэрийн агуйн нэртэй зургууд нэгэнт нээгдлээ.

Агуйн хана туургыг улаан, улаан хүрэн, ягаан өнгөөр зослосон төрөл бүрийн амьтны дүрсийг шинж төрх, хөдөлгөөн, харьцаагаар гайхам татаж зурсан нь "бодит арга барилт орчин үеийн зураач (анималист) зурсан шиг атаархам болжээ" гэж зарим судлаачид шагшсан байдаг. Гэтэл эрдэмтдийн судалгаагаар тус сүгийн чуулбар дээд чулууны үе буюу аргын тооллын өмнөх 20-15000 жилийн үед хамаарахыг тогтоосны дээр, зурсан арга барил, шинж, дүрслэлийн талаар ориньяк-перигордьенскийн бүлэглэлд багтана гэж үзсэн байна.

Хойт Цэнхэрийн агуйн сүгийг хадны бусад дүрслэлтэй харьцуулбал, тэнд тэрлэгдсэн "шинэс" (уд) модны зурлага нь өмнөт Францын Кастильо, Нио агуйн зурагтай адил байх бөгөөд ямааны зурлага нь Ляско агуйнхтай, арслан зааны бүдүүвч нь Ложерийн давхарласан дүрстэй, үхрийн мэт зурлага нь ялангуяа өнгийн хувьд умард

Испанийн Альтамир агуйнхтай төстэйвтэр байна. Эл агуйн зурагт байгаа толгой дээрээ гурван салаа эвэр мэт зурлагатай гөрөөсийн (ямааны) дүрс нь Сахарын Тассилийн элсэн манхан дахь гөрөөсний (ямааны) дүрстэй ижлэвтэр юм. Чулуун зэвсгийн сүүл үед хамруулж байгаа Төв аймгийн хуучин Өлзийт сумын хадны зураг дахь морины дүрсийг "том нүсэр биетэй, жижгэвтэр толгойтой богинохон үслэг хөлтэй" гэж археологч Д.Доржийн тодорхойлон бичсэн нь өмнөд Францын Ляско агуйн Фриз гэдэг "жижиг адууны" зурагтай төстэй гэж үзэлтэй.

Хойт Цэнхэрийн агуйн чуулбар дөрвөн хэсгээс бүрддэг. Нэгээхэн бүлэг зураг нь агуйн зүүн гар талын адарт улаан, улаан хүрэн өнгөөр үйлдэгджээ. Энд гол төлөв амьтны дүрс, эвэр, янз бүрийн урт богино зураас байна. Бүх бүдүүвч зурлагын хэмжээ ойролцоогоор 48 x 51 см, энд гөрөөс, аргалын дүрсийг чадмаг татжээ. Зураасны өргөн 5-10 мм орчим, түүний чадварлаг татлага нь Фонде гомын агуйнхыг санагдуулам ажээ.

Хоёр дахь бүлэг зураг агуйн амны эсрэг ханын адарт байдаг ба Баруун Европын Руфиньяк, Ляско, Нио агуйн зурлагатай адил эмх цэгцгүйгээр давхарлан зурсан зосоор өнгөлсөн зурлагатай, олон төрлийн толбо (цэг) тэмдэгтэй. Энд угалз, янгир, адуу, тэмээн хяруул зэргийг ихээхэн бүдүүвч дүрсэлсэн байх ба тэднийг гороо зураасаар онож татсан байна. Зурлага дотроос түгээмэл тархсан занга дохио бол "толбо" юм. Амьтны харалдаа цэг тавьсныг "хүйс" заасан тэмдэг гэх ба зарим толбот хувилбарыг судлаачид ав хомроогоо урьдаас гөрөөлж "шарх" оноосны дом гэж ялган тайлсан байдаг. Хонхойлж цөглөсөн тэмдэг бол ид шидийн үүдлээр "нүд" гэхийг үзүүлэх хувьтай. Магадгүй, дүрсээр ховсдох аргын талдаа ("парциаль", бас "симиль" угтлаар) занга нь зөвхөн далд хүчийг биш, зурлага үйлийг "бодитой юм" гэж ойлгодоогоос үүтсэн байж болох. "Нүд" тавьж харуулах нь сахиулсан амьтан гэсэн үг байж, ерөөс босоо чигт тэрлүүлдэг нь сүнсийг аргадсан хориг болдог. Үүнээс эргэцүүлэхэд, хүй нэгдлийн хадны бичээст амьтны сүнслиг оронг зааж ("занга") тэрлэх, онго титмээ сэтэрлэх ("ариун" зүйлийг төлөөлөх) үйлийг давхар оноодог нь домнох шид юу юунаас чухал байсныг илтгэнэ.

Тэр хэсэгт зааны дүрс тодорхой харагдана. Энэ нь монгол нутагт амьдарч байсан уугуул хүмүүс арслан заантай учирдаг байсныг хэлэх шиг. Арслан зааны яс монгол орны хойт хэсэг, Орхон голын эрэг, тэр ч байтугай Улаанбаатар хотын орчмоос олдсон нь ч тохиолдлын зүйл биш гэдгийг харуулдаг. Агуйн ханад зурсан арслан зааны дүрс нь Уралын болон Франк-Кантабрын бүс нутаг дахь агуйн зураг болон Сибирийн Волчья грива (Чонон дэл) гэдэг газраас олдсон 14000-15000 жилийн настай, сахлаг үс ноостой, өндөр өөвгөр нуруутай арслан зааны төрхтэй төрөл байдлаараа ижилгүй байгаа нь нэн сонирхолтой юм. Арван гурван мянган жилийн тэртээгээс нааш том арслан заан, үслэг хирс зэрэг амьтдын үлдэц олддоггүй гэж Өмнөт Сибирийг судлагч геологчид үзсэн байдаг. Дэлхийн цаг агаарын өөрчлөлтөөс үзвэл, монгол нутаг Сибирээс арай хожуу хүйтэрсэн байж таарах учир арван таван мянган жилийн өмнө ч тэнд арслан заан байсныг үгүйсгэмгүй. Харин зарим судлаачид нь хүмүүс амьд арслан зааныг биш нэгэнт мөхсөн амьтны үлдэцийг ер бусын ид шидтэн болгон зурсан байж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. А.П.Окладников Хойт Цэнхэрийн агуйн хадны зураг дахь зааны дүрслэлийг арслан зааных биш, өөр төрлийн зааных байж магадгүй гэж таамагласан байдаг. Хойт Цэнхэрийн агуйд арслан заанаас гадна тэмээн хяруулын бүдүүвч татлага тэрлэгджээ. Дэлхийн хөгжлийн геохронологийн хүснэгтээс үзвэл, тэмээн хяруул нь Кайнозойн эриний гуравдагч, дөрөвдөгч галав буюу 40 мянган жилийн тэртээгээс арслан зааны хамт хүний хөгжлийн чулуун зэвсгийн палеолит,

мезолитийн үед амьдарч байсан нь тодорхой. Өмнөговь аймгийн Шаврын ус гэдэг газраас тэмээн хяруулын өндөгний үлдэц олдсон нь тэр үеийн хүмүүс тэмээн хяруулыг биеэр нь харж хадны сүг зурагт дүрсэлж байсан гэдэг маргаангүй.

Хойт Цэнхэрийн агуйн гурав дахь бүлэг зураг агуйн амны чанх эсрэг талын адар тус газар байна. Түүнд тэмээ, салаа эвэр, шилмүүст мод, нисэж буй шувууд зэрэг сонирхолтой дүрс бүхий зурлага татагджээ. Энд буй тэмээний зогсолт нь дээрх хоёр бүлгийн зурагт буй зэрлэг хонь, ямааны дүрслэлээс арай өөр тавилтай (эгц хажуу байршилтай биш) харагдана.

Дөрөв дэх бүлэг зураг нь агуйн төв адарт байх ба гол төлөв цэг зураас, гурвалжин дүрс, эвэр хэлбэрийн дүрсийг хольж зуржээ. Тэдгээрийн дотор бас урт хөлтэй шувууны болон адууны дүрсээс гадна өмчийн тэмдэг танигдахуйц байдаг. Хойт Цэнхэрийн агуйн олон хэсэг дэлгэмэл зургийг дүрслэлийн үүднээс үзвэл, нийтдээ задгай зураасаар хөвөөлж болзшуулсан тавилт нь “хээл” (үр тогтох, гэдэс) гэх санааг дээдэлснийх бизээ. Хадны сүг зурлагад хэрчлээс бүдүүвч чухал үүрэгтэй. Тиймээс ч бүдүүвч татлагаар махчин, өвсөн тэжээлт амьтдын аль алиныг ёсолжээ. Үүнийг ертөнцийн үүсэл бүтвэрийн сэдэвт холбон жишихэд хэсэг бүр нь эр, эм хүйсийн зөнг эрхшээдэг. “Жигүүртний” (орнитоморф) зурлага үүнд багтана. Жигүүртнийг, тэр тусмаа эмэгчин талыг тэрлэдэг нь нэг талаас хол (хадан гэр) ойрыг (хүмүүн орон) холбогч мэт боловч, нөгөө талаас “хээл” даатгах тамлага учир дүрс гэхээс илүүтэй ердөө олшруулах тэмдэг байдаг. Олшруулах дом бол чулуун зэвсгийн тэртээд хүйс болоод үржих төлжихийг ёсчилдог бөгөөд ан авыг эрхлэх явцад үүссэн хэрэгцээ ажээ. Олшруулна гэдэг нь ахуй амьдралын утга учрын тухай асуудлыг шийднэ гэдэгтэй нэг адил ойлголт. Энэ тухайд францын эрдэмтэн Анри Брейль “Хэрэв олзоо аргадах чарга байгаагүйсэн бол балар цагийн байгалийг амьдчилан шүтэх урлаг байхсан болов уу” гэжээ. Тэгээд ч “олзоо” олшруулахын тулд дан ганц сийлж цохиж байсангүй, ургамлын хүчлээр идүүлж гор мөр гаргах ажиллабар үйлдэн хэрэглэдэг байсныг хэлэх нь зүйтэй болов уу.

Энэчлэн хүн төрөлхтний дом тэмдгийн эх үүсвэр өрнө дахинд байсан шиг дорно дахинд байсан гэдгийг эртний урлагийн голомт Хойт Цэнхэрийн агуйн сүг гэрчилж байна хэмээн археологич Д.Дорж үнэлж дэлхий дахины баларлиг үеийн нэртэй дурсгалтай эн зэрэгцүүлэн тавьсан билээ. Түүний энэхүү дүгнэлтийг Орос Монголын эрдэмтэд төдийгүй дэлхийд хүлээн зөвшөөрдсөн судлаачид дэмждэг юм. Гэвч, хадны сүг зурлага судлалын талаар зарим хүмүүс А.П.Окладниковын дүгнэлтэд эргэлзэх, түүний үнэ цэнийг багасгах оролдлого гарч байсныг бас дурдууштай. Тухайлбал, Э.А.Новгородова 1975 онд бичсэн номондоо Хойт Цэнхэрийн агуйн зурлагыг Мезолитийн үед холбогдуулан үзэхийг санал болгож байсан билээ. Эл маргаантай асуудлыг тухайн үеийн хүмүүсийн сэтгэцийн байдалтай холбон үзвэл зохилтой санагдана.

Яагаад гэвэл, айдас (Dasein) бол хүний ахуйн үндсэн араншин мөн. Иймд, хүнээс бусад нэг ч юм өөрийн төгсгөлийг, үхэх шинжийг мэддэггүй учраас зөвхөн хүнд оршин байхуй нь цаг зуурын мэт төрөгддөг. Далд хүч чадлыг эзэнтэй гэж төсөөлдөг нь дээр дурдсан санаанд илэрч байна. Ерөөс хүй нэгдлийн үеийнхэн уул усны эзэн савдаг хийгээд амьдралын холбоог зөвхөн “fellow-animal” мэдрэхүйн хүрээнд ойлгожээ гэж үзүүштэй.

Тухайн мэдрэмж бол хүн “төгсгөлт” амьдралаа үзэж байгаа, өөрийн дагуул болсон хувь тавилантайгаа харьцах харьцаа мөн. М.Хайдеггер ахуйлиг сэтгэлгээний хэв маягт

субъект бол би, би бол бусад, би битэйгээ адил бус гэдгийг онцлон дурьддаг. Зурлага талаасаа бол, эртний хүний сэтгэцийн байгууламж ямагт “өөрөөсөө гадна байх” зүйлийг аргадахад оршино гэсэн үг. Баларлиг үеийн хүнд үхэл, түүний дараах байдал чухал болж “хий сүг” босгох заншил дэлгэрсэн байна. “Хий сүг” аваас үхлийг мэддэггүй. Учир нь домгийн өгөгдлөөр түүний орших орон бол сүнслиг амьдрал гэх ойлголтыг илэрхийлдгээрээ өвөрмөц.

Хуучин чулууны шувтрага, мезолитын үед холбогдох хадны зургийн өөр нэгэн хөмрөг бол Хэнтий аймгийн нутаг дахь Аршаан хадны дурсгал юм. Хурх ба Онон голуудын завсар хөндийд орших Рашаан хад хэмээх эл уулын хадан байцаар түүхийн хэд хэдэн үед хамаарагдах, тамга дүрс, зосоор зурсан сүг зурлага, сийлмэл олон янзын дүрс тэмдгийн зүйл тэрлэгджээ. Ийм зурлага тэмдэг Дундговь аймгийн Цагаан айраг, Хэнтий аймгийн Үзүүр цохио гэдэг газар дахь хадны бичээсийн дотор бас үзэгдэнэ. Эдгээр зурлага тэмдгийн дохио зангыг одоо хир бүрэн зөв тайлбарлаагүй байна.

Рашаан хадны дурсгалын дотор амьтанчилж сийлсэн ганц хад байдаг. Энд гурван этгээдийг дүрсэлсэн байх боловч, чухам ямар занга дохио болохыг ойлгоход бэрхтэй. Судлаачдын нэг хэсэг нь хирс гэх, нөгөө хэсэг нь гахай гэх зэргээр таамагладаг аж. Барилын хувьд Хойт Цэнхэрийн агуйнхаас арай ялгаатай, амьтанчилсан зүйлээ битүү зураасаар бүтэн хөвөөлж тэрлэсэн байдаг. Үүнээс гадна юмсыг бодит байдлаар бүдүүвчлэн дүрсэлсэн байх эсвэл амин шугамаар буюу гурвалжин, дөрвөлжин, муруй зураас зэргээр хэтийдсэн байна. Тэр нь бүр цаанаа төрөх түрдэх ёр, бэлгэтэй холбогдсоныг үгүйсгэмгүй. Ийнхүү ан авыг олз омогтой байхыг домнож тайж тахиж байсан улбаа дараа дараагийн үе гарахад ч үргэлжлэн өвлөгджээ. Зурлагыг тэрлэхдээ дүрст холбохоос илүүтэй цэг зураасаар занга тавьж хориглох нь голлодог тул түүнд далд хүч чадлын тамлага харьцааг босгох нь элбэг байдаг. Тамлага харьцаанаас ангид зурлага дом үгүй шиг уул усны “эзнээс” тусдаа “сүүдэр” гэж бас үгүй юм. Сүүдэр (сүнслиг бие) тээх ёсондоо зурлага тамлага бол “юм”, “дом” хоёрын хоорондын харьцааг тэрлэх дохионы өрөлт байдаг. Тэрлэсэн дохио заавал амь чадлыг шидээр эрхшээх нь зайлшгүй бөгөөд цэг хэрчлээс болоод биеийн анги хэсгийн байршил ба бүдүүвчээс (хэмнэлээс) хамаарч үйлийнх нь тийн мэдэл, үүргийг үзүүлдэг талтай.

Уг асуудлыг Н.Цүлтэм “Европын агуйнуудад байдагтай нэгэн адил монгол дахь агуйн зурагт мал амьтдын реалист дүрслэлийн зэрэгцээгээр дэл, сүүл, эвэр, туурай зэрэг биений анги хэсгүүдээр тэднийг төлөөлүүлэн дүрслэж байсаар тэдгээр нь улам боловсорч, бидний хэмжихүй ухааны дүрс гэж нэрлэдэг дөрвөлжин гурвалжин, дугираг хэлбэрийн тэмдэг, тамгуудыг дүрслэх тогтолцоо чиглэл их дэлгэрчээ” гэж тайлбарлажээ. Ингэж үзэх үндэслэлээг Францын судлаач А.Леруа –Гураны тайллаас иш болгосон бөгөөд түүний баримтлалаар, палеолит болоод мезолитын урлагт байдаг товчилсон тэмдэг дүрслэл бол жирийн тохиолдлын биш түүний хамт зөн бэлгэдлийн үүдэлт тэмдгүүд гарч ирсэн нь тектиформ, клавиформ, скутиформоор эм талыг, пенниформ, шулуун зураас, олон цэгтэй зураас, пунктир зэрэг нь эр талыг төлөөлдөг гэсэн нь бий. Эдгээрээс эргэцүүлэхэд, монголын хүй нэгдлийн урлаг хүн төрөлхтний урлахуйн сэтгэлгээний нэгэн адил зурлага татлагын хэмжээ харьцааг ихэд шидэчлэн, цэг гороо тавьж амьтаншуулан үзүүлж чаджээ гэж үзэж болно.

Зэс чулууны (энеолит) үеийн хад, чулууны сүг зурлага Архангай аймгийн нутаг Чулуут голын эргээр ихээхэн элбэг тохиолддог. Иймээс Чулуут голын эрэг дагуух түүхийн дурсгалыг эрдэмтэд хадны сүг зургийн орд гэж зүй ёсоор нэрлэжээ. Энэ нутгаар хэд хэдэн удаа эрдэм шинжилгээний анги явж ажилласны үр дүнд түүхийн он

цагийн янз бүрийн үеүүдэд холбогдох 320 гаруй зурлага сүгийг хуулбарлан авч судалсан байна. Чулуут, Суман голын бэлчир хавиас олддог сүг татлагад хонь, ямаа, тэрэг зэргийн олон янз дүрсүүд зурагдсан байна. Тухайн орчинд явуулсан биологийн болон геологийн судалгааг үндэслэн тэндхийн хадны бичээс наандаж АТӨ 3000 жилийн өмнө үйлдэгдсэн гэж үздэг. Чулуутад Суман гол нийлсэн цутгалангаас хойш 26-30 км-т Ацатын горхи нийлнэ. Тэндээс 2.5 км орчим газарт том хүрмэн чулуун хананд зурагдсан төрж байгаа олон эмэгтэйн дүрсийг ойр ойрхон хагас дугуй хэлбэрээр эгнүүлэн холбосон нь гойд сонирхолтой юм. Эдгээр гороо татлага нь үйлдсэн арга барил, зан үйлийн хувьд харилцан холбоотой болох нь маргаангүй. Голлож тэрлэсэн зургаан сүгийг үндсэн хэсэг гэж хэлж болно. Том гэдэстэй хөл гар нь тохой, өвдөгөөрөө нугарсан зарим сарвагар дүрсэд эмэгтэйн хөхийг тодорхой харуулж эхийн хоёр суганы дор “мэнгэ” тавьсан байх ба нэг дүрсийн баруун дор гурван нарийн зураасаар холбосон байгаа нь хүйн элгэнээ (community) тайх гэсэн шившлэг байж болох юм. Сонирхол татах зурлага нь, хамгийн баруун захын дүрс. Энд нярайлах эхийг хоёр том хөх, толгой дээр нь бугын эвэр мэт зураастай, хөлийнх нь хооронд төрж байгаа хүүхдийг хүйгээр холбож дүрсэлжээ. Эврийн хэмжээг нийт биеийн овортой харьцуулбал үлэмж том байгаа нь чухамхүү “эвэр” эл зургийн хамгийн гол тодотгол болохыг цохон харуулах гэсэн мэт. Оросын зарим эрдэмтдийн үзэж байгаагаар эл зохиомж нь ураг таригийн ёсны талаарх “үржих” ойлголтыг энгийн хэлбэрээр тайж илэрхийлсэн явдал аж. Умард болон Төв Азийн ард түмний үлгэр домогт хүн төрөлхтний элэнцийг “бугын” дүрээр харуулдаг гэж ч байдаг. Харин энд буга бугадаа эмэгчин талыг онцолсон нь маш өвөрмөц. Бидний бодлоор бол, энэ нь Монголын нууц товчоонд гардаг Бөртэ-чинуа, Хоо-маралын түүхийг санагдуулам билээ. Э.А.Новгородовагийн хийсэн дүгнэлтэд иймэрхүү зурлагыг Алун-Хоотой холбон монголын боржигин овгийн үүсэл гарлыг дүрсэлсэн байж болно хэмээн бичсэн нь бий. Чингэвэл, монголчуудын үлгэр домогт гардаг марал нь бүр эртний, чулуун зэвсгийн үеэс сурвалжтай байж магадгүй нь ээ. Эвэртэн туурайтныг болоод согоог онго шүтээн болгон шүтэж ирсэн нь дүрчлэх (идол) сэтгэмжийн элдэв төсөөлөлтэй холбоотой бөгөөд тиймээс ч түүнийг хөшөө дурсгал, бугын чулуу, хүрэл зэвсэг, чимэглэлийн зүйлс, морины тоног зэрэгт шингээн дүрсэлдэг нь тохиолдлын зүйл бишээ.

Хүн-амьтан, хүн-араатан гэх мэтээр өөр төрхөд хувилган нийлүүлэн тэрлэдэг ёс хүй нэгдлийн нэлээд хожуу үед холбогдох зурлага билээ. Ложери-Бас агуйн зурагт том гэдэстэй эмэгтэй хүнийг цаа бугын дор гарагласан байна. Э.Г.Фрадкин хүн, амьтныг хооронд нь нийлүүлэн ховсолсон олон зурлагын бүтцийг харьцуулан судлаад ерөөсөө хоёр өөр төрлийн амьтныг төдийгүй тэс өөр шинжийг агуулсан ертөнцөд огт үгүй амьтныг онголох явдал одоогийн Ази, Африк, Америкийн ард түмний дотор ихээхэн түгээмэл байдгийг илрүүлсэн юм. Энэ нь заримдаа шидийг ховсдон хөгжөөх, лус савдгийн эзэн үгүй гэх төсөөллийг ер бус амьтны дүрээр нөхцөөх ба холонц эхээ зооморф, антропоморф хэлбэрээр дүрсэлдгээс ялгагдах хувилбар хаа сайгүй тархсныг гэрчлэх билээ.

Чулуут голын зурлагыг өмнөд Сибирийн Черновая, Тепсей зэрэг газраас олдсон эмэгтэйн дүрсүүдтэй харьцуулахад агуулгын хувьд төстэй, хүрлийн түрүү үед хамрагдана гэж үздэг байна. Э.Б.Вадецкаягийн таамаглалаар, эдгээр зурлага нь холонц эхийг харуулсан бөгөөд тухайн үедээ хүүхэд төрүүлэхэд бие сэтгэлийг хөнгөрүүлэн тайтгаруулах шүтээн (ариун орон) болгон ашиглагдаж байсны гэрч юм гэжээ. Чулуутын зурлагад буй нэгэн ялгаатай зүйл гэвэл эмэгтэй хүнийг бугын эвэртэй “эрхэс

мэт" (солярный) дүрсэлдэг бол, харин Сибирийн хувилбарт эврийг бухын дор байгаагаар домножээ. Хүйгээр холбогдсон эхийн ариун бэлгэдэл зөвхөн Чулуутын хадны зурлагын хөмрөгөөр хязгаарлагдалгүй монголын говь дахь дурсгалд ч бас бий. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Тэвш уулнаас олдсон хадны зурлагад төрж байгаа эхийн гар хөлийг алдалсан байдлаар тэрлэсэн нь Өмнөд Сибирийн сүг бичээстэй нэлээд төстэй байна. Энэ бүхнээс үзэхэд, Чулуут голын эргийн ханан хаданд тэрлэгдсэн дом зурлага зөвхөн эх хүн, буга-эхийн онготой холбогдох бус гараг эрхэсийн хүйн гарвалтайг заасан мэт. Мөн хадан зурлагад дээр дээрээс нь хоёр, гурав, дөрөв, түүнээс ч олноор угсруулан чагталсан эмэгтэйн дүрс байх ба хамгийн доод талын эмэгтэйн хөлийн хооронд хүйгээр холбогдсон (бүдэгхэн харагдах төрж байгаа) "үр", хамгийн дээд хэсэгт нь "уд" маягийн эрхэсийг төлөөлүүлжээ. "Шүтээн" модны гарвалын адил бүтцийг хүншүүлэн галбиржуулж "сакраль" загвар болгосон нь эмэг эх, эх, охин гэх мэтээр үргэлжлэх эхийн талын цусан холбоог хамгийн ойлгомжтой, хураангуй бүдүүвчээр гайхамшигтай харуулж хүн төрөлхтний үе удам хэзээ ч тасаршгүй гэх шившлэгийг шингээжээ. Энэчлэн монголын хадан зурлагын дотор орчлонт ертөнцийн байдлыг холонц эхийн буюу ариун орны зурлага тигээр дурдсан нь цөөнгүй тохиолдох тул тэдгээрийг мэдээ болгон өгүүлье. Учир нь "уд" буюу гал-нарыг тээх холонцоо "далд зээн", "эх" хоёрыг хүйн гарвалтай гэж тайж тахидаг явдал байна.

Олон давхар цувруулсан мод мөчир мэт салаалсан зурлага ганцхан энд биш, бас Увс аймгийн Наранбулаг сум, Ховд аймгийн Ховд хотын ойролцоо, Архангай аймгийн Хуруугийн үзүүр зэрэг газарт олонтоо тохиолдоно. Өмнөговийн Аравжах, Өвөрхангайн Тэвш уулын хадны сүгт байгаа эмэгтэйг тэнгэр эрхэст хандсан гурван салаа сарвуутай домножээ. Ийм дом Азийн бусад орон, Солонгос, Хятад зэрэг орны хадны зурлагад бас бий. Хятадын хүрлийн үеийн хадны сүг зурлагын дотор тус нутгаас олддог "төөрөг муруй" (лабиринт), түүний ойролцоо олон давхар эгнээгээр, гараа тэнгэр өөд хандуулсан залбирлын өргөл бас тэрлэгджээ. Элэнц хуланц эх, эцэг өвгөдийн ариун сүнснийг "эвэртэй", "жигүүртэй" амьтны хэлбэрээр илэрхийлэн харуулах санаа дэлхийн газар бүхэнд хөгжлийн нэгэн ижил үе шатанд үүсэж бүрэлдсэн гэж үзвэл зохино. Баруун өмнөд Азийн эртний уугуулууд ч гэсэн өвөг дээдсээ араатан амьтан буюу шувуугаар онголж бас ариун сүнснийг эрхэмлэж байжээ. Судлагдсан бүхий л зурлагыг харьцуулан үзвэл, тухайн сэдлийн гарвал эр, эм үүтгэлд ангилагдахаас гадна толгой дээрээ бугын эвэртэй буюу шинэс модны мөчир шиг зурлагатай, ромбо маягийн багтай, гурвалжин, бөөрөнхий, дугуй, хэрэгсэлтэй (дуулга мэт), хэрэгсэлгүй гэж ялгаж болмоор байна.

Чулуутын зурагт эм үүтгэлийн хамт бух дагуулсан ёсчлол олон бий. Ерөөс зэс чулууны үед бухыг сул дагуулдаг зан үйл нь хүй элгэндээ одох гэсэн санааг илэрхийлдэг. Амьдралын жамыг өгүүлсэн тайлга тахилгын зурлага Баянхонгор аймгийн Бичигтийн ам, Говь-Алтай аймгийн Цагаан-гол, Бигэр сум, Ховдын Ямаан усны хад, Өмнөговь аймгийн Аравжих, Өвөрхангайн Тэвшийн хадны зурагт бий бөгөөд ерөнхийд нь хүрлийн үеийн дурсгалд хамруулан үздэг. Эдгээр төөрөг зурлагыг хүрлийн үеийнх гэж тогтоосон нийтлэг үндэслэл нь нэгдүгээрт тэрэг оньслогдсон, хоёрдугаарт Тува, Өмнөд Сибирь, Алтайн хүрлийн үеийн сүг зурлагатай ижил төстэй, гуравдугаарт нум тэлэн хэнгэрэг дэлдэж байгаа хүн дүрслэгдсэн, дөрөвдүгээрт даль хэлбэрийн юм аль алинд нь тэрлэгдсэнд оршино. Түүнээс гадна сүйх тэрэгний оньс хүрлийн үеийн бүхий л дурсгалд элбэг тохиолддог. Тэрэг, сүйх тэрэгний оньсон сэдлийг нэлээд олон жилийн өмнө монголд нээснээс хойш багагүй судалжээ. Одоогийн байдлаар тэрэг,

сүйх тэрэг дүрсэлсэн 22 хадны зурлагыг Алтайн нурууны говийн бүс нутаг хавиас, 20 гаруйг монголын хойд хэсэгт буюу Чулуут голын дунд биеэс олсон юм. Бас нэг судлууштай олдвор бол Говь-Алтай аймгийн Цагаан голын зүүн эргийн хавцлаас археологч Ц.Доржсүрэнгийн илрүүлсэн сүг юм. Энэ бүлэг сүгт Хүннү-Саргиатын үеийн тамганы дүрсүүд болон оршуулах үйл ёстой холбогдсон тайлга ихэнхийг эзэлжээ. Хавцлын нэгэн хэсэгт орших ханан хаднаа 3 метрийн өндөрт 3 тэрэгний дүрс байдаг. Тэр бүгдийг моринд хөллөөгүй, ачаалаагүй байгаагаар дүрсэлжээ. Тэрэгний дүрсийн хамгийн том нь 27см x 15 см, бага нь 10см x 7.5см хэмжээтэй энгийн товчхон зурагдсан боловч эд ангийг тодорхой харуулсан онцлогтой байна. Тэрэгний гуя нь буулга бэхэлдэг хөндлөн чагттай, чагтны үзүүр нь ялимгүй махир, гол дээрээ жижиг аралтай. Хамгийн бага тэрэгний дугуй нь хигээсгүй бусад нь 6-8 хигээстэй. Бүх тэрэгний бүтэц ижил, аль алиныг сийлж үйлдсэн ба нэгэн үед хамаарагдах үндэстэйг маргаангүй харуулж байна. Үүнээс улбаалбал, бүх сул дагуулдаг, тэрэг ачлагагүй хөллөдөг зан үйл бүхий сэдэл (мотив) хаа сайгүй адилавартай байгаа нь яалт ч үгүй удган эхийн ёслолтой холбогдох зүйл гэдгийг магадлана. Удган дайрлага дайрсныг зайдан унаагаар төлөөлдөг. Түүний жолоо цулбуурыг сул орхивол ижил сүрэгтээ нийлдэг гэсэн санаатай байж.

Чулуутын зурлагад дүрслэгдсэн ямаан эвэртэй том амьтан, бухын биетэй, буга шиг толботой хоёр амьтны ойролцоо явган дайчин, тулааны зориулалттай тэрэг нэг дор зурагджээ. Хадан дээрх хүмүүсийн дүрс янз бүрийн, ихэнхдээ өргөн хүрээтэй сар маягийн багтай. Тэд нум, сум, сүх зэрэг зэр зэвсэгтэй аж. Энд морь унасан байлдагч байхгүй байгаа нь уг сүг скитээс өмнөх үеийнх гэдгийг тойруу замаар нотлож байна. Хамгийн гол нь тэргэнд буга юмуу, "эсвэл бугын багтай морь" хөллөсөн байна. Морьд нь тэрэгний гол гуяны хоёр талаар хөлөө гадагш нэг тийш харуулсан, тэрэгний тэвш нь гол дээрээ голлосон биш, харин голд тулсан мэт нэлээд урдуур байрласнаас үзвэл Ойрхи Дорнод болон Хятадаас олдсон тэрэгний бүтээцээс ялгаатай байдаг. Тэвшин дээр гурван хуруу бүхий сарвуутай, хөлөө хол алцайж зогссон эмэгтэй хүнийг онцолжээ. Түүний баруун гар талд нум сумтай анчин, дор нь хэд хэдэн буга, бор гөрөөс байна. Эр эм хүмүүс цөм шовх оройтой сар мэт багтай. Тэргийг хавтгайд зураглахдаа синтаксис өрөлтөөр тал тал тийш нь харуулж загварчилжээ.

Чулуутын "фронталь" байгуулалт бүхий зурлага нь олон харааны тусгалыг нийлгээр нь товлож зурдаг аргатай нийцнэ. Үүнийг "тэрэг" гэхээс илүүтэй тэнгэрийн орныг зүглэгч "хүрд" гэж үзвэл зохилтой санагдана. Яагаад гэвэл, тэрэгний бүтээцийг огторгуйн төвд тиглэж, тал бүрээс нь харсан мэт байгууламжаа галбирын жишмээр нээж чаджээ. Эл тиг дээрээс харсан гэмээр боловч хөдөлгөөн, байршлыг хавсаргаваас орчлонгийн далд хүчийг чөлөөтэй сэлгэх арга үүсгэвэр болсныг илтгэх мэт.

Баянхонгор аймгийн Бичигтийн амны хадны зурлага дотор хэнгэрэг мэт зүйлийг дэлдэж буй хосгүй бичээс бий. Дэлдэгчийн эсрэг уруу нь харуулж хөлийг нь эмэгтэй хүний хөлийн дээгүүр дамнуулан тавьсан байдлаар зуржээ. Энд олз арвин байхын шившлэг үйлдэх болон үр үндсээ эрхэмлэх хоёр шүтээний хэлбэрийг солбицуулан үзүүлсэн бололтой. Зарим нэг амьтны дүрсийг гурвалжин, дөрвөлжин, цэг мэтийн дүрс тэмдэгтээр эрээлж хувилгасан нь анхандаа анимизмын шүтээний зан үйлд холбогдон гарч ирээд дараа нь чимэглэлийн хэмнэл болон хувирсан бугын загвараар, яваандаа Түрэгийн үеийн тайлга тахилгын "гэтлэсэн дүр" болсон гэж Оросын эрдэмтэд үзжээ.

Тэрэг, дайчин, анчин, нум сум, сар мэт баг, морь тэрэгний буулга, могой гэх мэт зурлага дүрс нь хүрлийн үеийн төрхийг харуулна. Монгол орны баруун болон зүүн

хэсэгт олдсон хүрлийн сүүлч, төмрийн түрүү үеийн хадны зургийн дурсгал нь зурлагын хувьд хоорондоо эрс ялгаатай байгаа нь анхаарал татдаг билээ. Зарим зохиомжид “задгай” тавилтай, дийлэнхдээ дөрвөлж хүрээтэй, дугуй буюу зууван толбыг дүрсэлсэн байдаг. Түүний хамт гар гараасаа барилцсан гэмээр хүмүүсийн бүдүүвч дүрс (магадгүй бүжиглэж байгаа юмуу гэмээр), далавчаа дэлгэсэн шувуу, эсвэл морь, нохойн дүрсээр төгссөн байна. Ийм дүрслэл Улаанбаатар хотын ойролцоо Гачууртын аманд бий. Түүнийг ёсчлохдоо хадны зүүн хэсэгт хоёр жижиг хүрээ татжээ. Нэг нь арван нэгэн цэгтэй, нөгөө нь чагт хэлбэрийн зураасаар дөрвөн хэсэгт хуваагдсан байх ба хажууд нь хоёр хүн амьтныг “сул дагуулж” (эзэнгүй) байгаагаар бас л дүрсэлжээ. Дээд талаар нь, зэрэгцээ хоёр шугам татаж дээд доод талд нь урт сүүлтэй адууны дүрсийг ижил хэмтэй зуржээ. Амьтныг дүрслэхдээ хөдөлгөөнтэй, хөлийг хагас нугалсан байдалтай, эхний морины хүйсийг тэмдэглэсэн дүрстэй байна. Эл тахилгын зурлага хоёр том шувууны дүрсээр төгссөн байна. Зохиомжоороо ойролцоо тахилгын сүг Улаанбаатарын өмнө этгээд дэх Богд уулын Их тэнгэрийн амнаас бас олдсон байна. Энэ мэт хадны сүгийн олдоц бууцны хамгийн өмнөд хязгаар нь Туул голын сав газар, хойд хязгаар нь Байгаль нуурын чанд, баруун зах нь Хөвсгөл, Булган аймаг ажээ. Сэтгэмж дүрслэлийн шийдлээрээ төсөөтэй дүрсийн байгууламж дээрх аймгуудаас гадна Говь-Алтай аймгийн Цээл, Наран сумын хооронд орших Цагаан голын хадан зурагт ч тохиолдож байгаа бөгөөд тэнд буй бүргэдийн дүрс нь “Их Тэнгэрийн бүргэдийг бодвол толгой нь гурвалжин, сүүл нь доошоо өргөссөн маягтай (3x12,5) зурагдсанаараа ялгагдана” гэж Ц.Доржсүрэн тэмдэглэсэн байна. Харин Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутгаас олдсон зурагт нар, хонхтой бөө, түүний дэргэд баавгай дүрслэснээр онцлог талтай юм. Мөрөн голын эргээр хэсэг зосон зураг бий. Дүрсийн зарим хэсэг нь арилж үгүй болоод, нөгөө хэсэг нь дөнгөж харагдах төдий байгаа билээ. Энд нийтэд нь зосоор өнгөлсөн тэгш бус хэмтэй хоёр дугуй, түүний зүүн талаар зэрэгцээ хоёр зураас татжээ. Баруун талаар нь далавчаа дэлгэсэн шувуу дүрсэлсэн байна. Дэлгэсэн далавчны нь байдал, сүүлний хэлбэрийг ажвал бүргэдтэй төстэй. Үүнээс баруун тийш хүрээ гарган голд нь хүний дүрс, түүнийгээ тойруулан олон цэг зурсан байна. Хүрээний гадна, доод талд нь гар гараасаа барилцсан гурван хүн, тэдний өмнө нь жижгэвтэр биетэй, урт сүүлтэй, урт чихтэй хоёр морьт дүрсэлжээ. Хамгийн эхний морийг хүн сул хөтөлсөн байх бөгөөд нохойн дүрсээр төгсжээ. Үүний дээд талд хоёр анчин янгир харваж байгааг дүрсэлсэн байна. Энд буй бас нэгэн өвөрмөц сэдэл бол зэрлэг гахайг (бодон) шүдээ ярзайлгасан чоно гэмээр амьтан хөөж яваагаар зурсан байна. Гахайн зураг Монголд төдийгүй бас Дорнод Испанийн Гасеулла болон Кастемон хавцалд зэрлэг гахай агнаж буй зураг байдаг байна. Бодон гахайн дүрс бүхий хадны дунд хавьд бөөгийн хэнгэрэг мэт дугуй зүйл бий.

Ялангуяа энэ үеийн хадны зурлагад шинээр үүдсэн сэдэв бол араа шүдээ арзайлгасан араатны загвар болно. Махчин араатан өвсөн тэжээлтнийг ноцож дайрах, идэш болгох мэт явдал баруун монголын сүг дотор дайралддаг нь монгол нутгийн зүүн болон хойт хэсэгт тэрлэгдсэн өгүүлэмжээс нэлээд ялгаатай байдаг. Тэдгээрт үйл явдлаа бусад хэсгээс тодруулан илүүц элдэв зүйлгүй дүрслэдэг. Ийм барил сүг зурлагаар тогтохгүй бага оврын цутгамал эдлэл, туурган хөшиг зэрэг тахилгын болоод гоёл чимгийн зүйлд бас нэвтэрчээ. Дүрслэлийн хувьд хүүрнэх шинж давамгайлж, тохиолдсон зүйлээ зураглах, түүнд хөдөлгөөний элдэв агшинг багтаах, зурлагын битүү сүүдрэгийг (силуэт) цул авах, татлагыг эрчтэй үзүүлснээр өмнөх бүх үеэс эрс ялгагдах

байдал ажиглагдана. Шүтлэг зан үйлийн талдаа домог зүйн сэтгэлгээний алив хувилбараас өвөлсөн бөө мөргөлийн уламжлалт санаа сэтгэмжийг харуулах мэт.

Хүрэл зэвсгийн үеэс хойших мөчлөгт ан агнуур мал аж ахуйд бариа тавьж өгсөнөөр онго амьтдаас илүүтэй уналга хийгээд оньсон сэдлийг тахих нь эрхэмлэгдэн үргэлжилж байлаа. Өдгөө Дундговийн орон нутгийг судлах музейн санд хадгалагдаж буй тал товгор байдлаар урласан, тайлга тахилгад зориулсан уналгын (морийг) зүйл үүнд орно. Хүннүгийн булшнаас гардаг морьдын загварчлал галбирын хувьд тун төстэй хийцтэй нь дээрх санааг улам тодотгож буй. Иймэрхүү дурсгалыг судлаачид амьтны загварт урлагт багтаан судлан шинжээд Скит болон Төв Азийн нүүдэлчдийн амьтныг загварчлан дүрслэх аргын нөлөөн дор хөгжсөн гэх хандлагатай байна. Тодорхой загварыг дүрслэлийн хувьд нь ингэж үзэхийг бас чиг үгүйсгэдэггүй. Тэд нөлөөлсөн гэх үндэслэлээ голцуу зохиомжийн тогтолцооноос, сэдлийн холбоос болоод загварчлах элементийн үүрэг, тавилаар жишиж хөнджээ. Гэвч хялбаршуулсан тигийн тархсан явцыг дүрслэлийн хувьд биш харин галбирших харьцаа, байгуулалт бүтцийн хувьд нь төсөөтэй талыг онцлох байдлаар аналогийн аргыг хэрэглэвээс дурсгал нэг бүрийг адилтгах аргагүй юм. Юу гэвэл, зөвхөн амьтныг загварчилдаг арга тогтсон бус хээ угалзын хэмнэлийн үелэл, харьцаа, хэмжээг загварт оруулж сэтгэдэг барил манай нүүдэлчдийн бүтээсэн зурлага сүгээр тогтохгүй гар урлалд ч зонхилж байлаа. Хэллэгийн дотор “гарагсийн” (солярный) тэмдэг зурлагыг хээ угалзны давтамж сэлтэд тохируулж галбиршуулдаг хатуу дэг ч бий. Хэрэв өмнөх үеийнхний зурлагад болзолт шинжийг утгашуулж онголсон гэвэл хүрлийн үеийн сүгийн загварчлах шийдэлд амьтны болоод хээ чимгийн тогтсон таалалд бүтээцийг байгуулалтаар хялбаршуулсан хийцээрээ илт ялгамжтай болж өрөлт, орон зайн тусгалын үндсэн ойлголт нарийссан юм. Энэ онцлог Баян-Өлгийн Бугатын Халзан булаг, Өвөрхангайн Өлзийтийн Шар булгийн Онц, Говь-Алтайн Нарангийн Цагаан гол, Өмнөговийн Ноён сумын Завсар уул, Аривжихын хадны зурлагын хэв маягт шингэжээ. Ийм барилтай дэг хүрэл хутганы ишэнд хэлбэршсэн байх ба гурвалж, дөрвөлж, тахир, дугуй, хөвөө зураас, хажлага зураас мэтээр давхар чимэглэгдсэн байх нь элбэг. Эдгээр хээ чимэг бүхий зурлагад утга буй. Хэрэв гурвалж бүтцийг тахирлаж хөвөөлбөл, “цагалбар мөчлөг” бүрийг заасны шинж. Үүнийг зарим судлаачид “могой” гэж үздэг боловч В.Е.Ларичев зэрэг эрдэмтэд од эрхисийн тохиолыг эрхшээх лит гэдэг. Ерөөс “илт оноохуй” мэт тахиралдсан шугаман хээний ёгтлол бол ан авд олон жил (өнө удаан) олз омогтой байхыг шидэлдэгээрээ нэн сонирхолтой дүрс загварын тоонд ордог юм. Ийнхүү хүрлийн үеийн зурлага сүг галбиршлын хувьд төдийгүй утга агуулгаараа ч өргөжиж, хийц хэлбэр нь ялгарч иржээ.

Эцэст хэлэхэд, хүй нэгдлийн нийгмийн сүг босгох дадал үйл үндсэндээ хаа сайгүй ойролцоо хөгжилтэй байжээ гэмээр. Эртний голомт бууцнаас олдсон үлдэц, хад агуйн зурлагын чуулбар ч үүнийг магадладаг. Гэхдээ энэ нь газар газрын дом зурлагын хийц, галбир яг адил байдаг гэсэн үг хараахан биш. Өөр тив бүрт амьдрагч хүний ахуйлиг нөхцөл нь газарзүйн орчин, цаг уурын байдал, эрхлэх үйл хөдөлмөр, ертөнцийг хүлээн авах мэдрэмж, зан заншлаар хэлбэрших шүтлэг зэргээс хамаараад хэлний тэмдэг, зурлага ангид хийц хэллэгтэй байдагт оршино. Тус нутагт идээшигч овгийн байгууллын хүмүүсийн хамгийн гайхам ул мөр гэвэл байгалиас ангижраагүй “цэвэр амьдчилах ёгтлол” байж хуучин чулууны дунд шатлалаар дамжаад бүр хүрэл, төмрийн түрүү үе хүртэл тасралтгүй зан үйл тайлга тахилгаа мөрдсөнийг гэрчлэх түүхээ, “хий сүг” босгох дом шившлэгээ (мэдээллээ) болгон тэрлэсэн явдал мөн. Сүг галбирыг

шинжихэд нэгд, өөрсдийн төсөөллөө ац зурлагаар (хээл, хүйсийг) бүдүүвчилж, хоёрт, амьтны дүрсээ (онго, сүүдрийг) гороолж ерөнхийлөн, гуравт, амьтны бодийг (сүнс, амийг) хялбаршуулж загварчилсан зэрэг утга санаа бүхий байна. Дүгнэвэл, зурлага үүдсэнээс аваад дүрсээр утга тэлэх болсон явц нь хүйсийн мэдрэмж дохионы шаардлагын оролцоогоор галбиршсан аж. Хадны сүгийн тэмдэг сэлтэд эхлээд хүйс ялгах нь толбо зураасаар өдөөгдөж байснаа эрхлэх ажил шүтлэг заншилтай сүлэлдэн хувилбаршсан байж. “ХЭЭЛ ХЭЭ” (гэдэс, сав) мэтээс “УМАЙ НЭГТЭН” хэмээх мета зурлагад сэлгэхдэхдээ амьтны буумал төрхөөр (зооморф) утгашиж дэлгэрчээ. Тэгэхдээ амьтныг олшруулсан гороо тиг нь “ШИД” (үс, хумс), “ХЭМНЭЛ” (мөр, ховил) нэгэн дор шившигдсэнээр мистик сэтгэмжтэй болж тогтсон. Энэ нь fellow-animal хэмжүүр үүсгэн шалгуур тавьж хориглодогт байгаа билээ. Иймээс асуудлын гол нь баларлаг хүмүүс бэлгийн өдөөлөг, дур хүслээ амьтны инстинктив хамгаалалттай жишиж ер бус цээрийг (эерэг тэсрэг эсрэгцлийг) занга тавьж номхотгодог үндэслэлийг ялгавартай авч үзэх нь зүйтэй мэт.

Ашигласан ном

Монгол хэлээр

1. Болдбаатар Ч, Бадрах Б. Homo Sapiens-ийн оюун сэтгэлгээний биет ба биет бус дүрслэл, түүний бэлгэдэл// Монголын соёл, урлаг судлал т1-4, УБ., 1999
2. Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг// Эртний судлал угсаатны зүйн бүтээл, УБ., 1963
3. Дорж Д. Тэвшийн хадны зургууд// Монголын хүрлийн үе, УБ., 1965
4. Доржсүрэн Ц. Говь-Алтайн Цагаан голын хадны зураг// Эртний судлал угсаатны зүйн бүтээл, УБ., 1963
5. Намнандорж О. Орон нутгийг судалсан экспедицийн замын тэмдэглэлээс// Ш.У. №1 УБ., 1975
6. Санжмятав Т. Архангай аймаг дахь эртний түүх соёлын дурсгал// УБ., 1973
7. Сэр-Оджав Н. Монголын төв умар хэсгийг археологийн талаар судлан шинжилсэн нь// Монголын хүрлийн үе, УБ., 1965
8. Цүлтэм Н. Монголын урлагийн тойм (нэн эрт цагаас XX зуун хүртэл), УБ., 1971
9. Цэвээндорж Д. Монголын палеолит, УБ., 1978
10. Цэвээндорж Д. Монголын нутгаас олдсон буган чулуун хөшөө// Археологи судлал, УБ., 1979
11. Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал, УБ., 1983
12. Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх, УБ., 1983

Орос хэлээр

1. Абрамова З.А. Палеолитическое искусство, М., 1970
2. Баас Ф. Ум первобытного человека, М-1., 1926
3. Бергсон А. Длительность и одновременность// Academia 1923
4. Болдбаатар Ч. Проблема происхождения палеолитического изобразительного искусства Центральной Азии, Репринт доклада. М., 1975
5. Дорж Д, Новгородова Э.А. Петроглифы Монголии.
6. Ларичев В.Е. Азия далекая и таинственная. Н., 1968

7. Леви-Строс К. Миф, ритуал и генетика. М., 1978
8. Леви-Брюль Л. Сверх-естественное в первобытном мышлении. М., 1994
9. Леруа-Гуран А. Религия до истории// Первобытное искусство. Новосибирск., 1972
10. Окладников А.П. Центрально-Азиатский очаг первобытного искусства// ВАН СССР №1 1972
11. Окладников А.П. Петроглифы Монголии. М., 1981
12. Столяр А.Д. Происхождение изобразительного искусства. М., 1985
13. Фрейд З. По ту сторону принципа удовольствия. М., 1925

Бусад гадаад хэлээр

1. Boncher de Perthes. Antiquites Seltignes et Antediliviennes t I.P., 1847
2. Breuil H. L'occident* patrie du grand art rupestre// Mlanges Pittard, Brive 1957
3. Breuil H. Quatre cents siecles de l'Art parietal. 1952
4. Graziosi P. Die Kunst der Altsteinzeit. Florenz. 1956
5. Leroi-Gourhan. A. Les religions de la prehistoire. Paris. 1964
6. Leroi-Gourhan. A. Prehistoire de l' "Art occidental, Paris. 1965
7. Piette E. Etudes "VII. Classification des sediments formes dans les cavernes pendant l' "Age du Renne-L" " Anthropologie t.XV. Paris. 1904
8. Pouha P. Trinacetisik kilometru Mongolskem. Praha. 1957
9. Spenser, Gillen. Native Tribes of Central Australia. 1989
10. Tylor E.B. Primitive Culture. London. 1871

SUMMARY

Process from a single drawing to meaningful figure is formed by the feeling and signing of sex. In rock paintings, distinguishing sex was firstly shown as a drawing but it changed in connection with their beliefs, hunting and lifestyle. Transforming meta-drawing from "ХЭЭЛ ХЭЭ" (stomach, womb) to "УМАЙ НЭГТЭН" (womb of the same) is spread meaningfully by zoomorphic figure. Contour of animals was formed the mysterious imaginations as "MAGIC" (hair, nail) and "RHYTHM" (line, groove). This is prohibited by criterion of fellow-animal. So, the question has to be connected to the primitives' lifestyle.